


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 03 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-13 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **899** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 899 тохиолдлын 93% /833/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 7% /66/ нь орон нутагт (Баян-Өлгий /24+6/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5/, Төв/16/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 240 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **13** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.03.23 - 03.29)

2025 оны эпидемиологийн 13 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **63** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 26%-иар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 43%-иар өссөн үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-13 дугаар долоо хоногт нийт 240** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


125Эмнэлгийн
тусламж авч буцсан**115**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
45%Эмэгтэй
55%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 13 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **23** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 8%-аар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 2 дахин өссөн байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 13 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	0	13	13
2	Эмийн хордлого	10	0	10
Нийт		10	13	23

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санамсаргүйгээр** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд тохиолдлын 80%-ийг 0-9 насны хүүхдүүд эзэлж байна. Шалтгаанаар авч үзвэл шил угаагч, хувцас зайлагч зэрэг ахуйн болон цэвэрлэгээний бүтээгдэхүүн, зэв арилгагч, бензин, батарей зэрэг машин, техникийн зориулалттай бүтээгдэхүүнд хордсон байна. **Санаатайгаар** эмийн бодисын хордлогод өртсөн тохиолдлуудыг авч үзвэл 21-ээс 47 насныхан байна.

-оОо-